



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дөрвөлжин сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2025/097/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улиастай сум

2025 он

Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын

тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraad@audit.gov.mn

Аудитын менежер :Х.Болдбаатар

Утас:99105506

Цахим хаяг: Boldbaatar.kh@audit.gov.mn

Аудитор: Д.Пүүжмаа

Утас:99080797

Цахим хаяг: puujmaad@audit.gov.mn:

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан

 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

ДӨРВӨЛЖИН СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА В.УРАНЧИМЭГ-Т

2025.02.22 № 229

танай _____ -ны № _____ -т

СӨРӨГ ДҮГНЭЛТ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дөрвөлжин сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн бөгөөд өргөн тархсаныг хангалттай, зохистой аудитын нотолгоонд үндэслэн Дөрвөлжин сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй гэж үзсэн.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Дөрвөлжин сумын Засаг даргын Тамгын газар нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин телевизийн нэвтрүүлэг бэлтгэсэн, бэлэн мөнгөний тайлан гаргаагүй, төсвөөс хөрөнгө зарцуулан хийлгэсэн ажлыг хүлээн авч биелэлтийг тооцоогүй, зардлыг зориулалт бусаар зарцуулсан, цалин амралтын мөнгө, тэтгэмжийг алдаатай тооцоолон олгосон, өмнөх аудитаар гаргасан төрийн албан хаагчдыг төсвийн мөнгөөр аялалд явуулсан зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-2 зэрэг заалтуудтай нийцэхгүй, тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Дөрвөлжин сумын Засаг даргын Тамгын газар нь тайлант онд хандив тусламж болон ОНХС-аас үнэ төлбөргүй хүлээн авсан 714,0 сая төгрөгийн хөрөнгүүдийг данс бүртгэлд тусгаагүй байсан алдааг аудитын явцад залруулсан байна.

Аудитын гол асуудал

Дөрвөлжин сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчсөн, өмнөх аудитаар гарсан алдааг давтан гаргасан зэрэг алдаа, зөрчил илэрсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 66.2 сая төгрөгөөр Спорт заалны

D:\disk\Албан бичиг\Дүгнэлт

812503387

дээвэр засварлах ажлыг Түмэн засал ХХК-аар гүйцэтгүүлэн ажлыг бүрэн хүлээн авсан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>32,623,641.14</u>	<u>32,735,308.30</u>
33	АВЛАГА	6,259,408.14	5,336,575.30
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	402,099.49	-
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	128,556.00	128,556.00
335	Бусад авлага	5,728,752.65	5,208,019.30
33510	Байгууллагаас авах авлага	668,752.65	148,019.30
33520	Хувь хүмүүсээс авах авлага	5,060,000.00	5,060,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	26,364,233.00	27,398,733.00
351	Түүхий эд материал	10,553,953.00	10,553,953.00
35110	Тусгай зориулалттай материал	10,553,953.00	10,553,953.00
354	Хангамжийн материал	15,810,280.00	16,844,780.00
35410	Бичиг хэргийн материал	2,077,000.00	2,299,400.00
35420	Аж ахуйн материал	5,224,180.00	6,036,280.00
35470	Бусад хангамжийн материал	8,509,100.00	8,509,100.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>827,594,741.49</u>	<u>1,798,010,553.43</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	827,594,741.49	1,798,010,553.43
392	Биет хөрөнгө	816,855,241.49	1,787,421,053.43
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,037,967,030.39	1,260,732,930.39
39202	Хуримтлагдсан элэгдэл	(488,719,963.44)	(544,969,388.70)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	97,544,800.00	344,744,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(83,816,049.87)	(103,424,383.09)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	155,770,618.80	293,938,793.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	(131,875,528.56)	(116,256,686.50)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	41,092,236.00	100,457,766.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(36,072,235.83)	(4,909,579.73)
39214	Бусад үндсэн хөрөнгө	235,917,320.00	617,203,601.22
39215	Хуримтлагдсан элэгдэл	(11,177,086.00)	(60,320,899.96)
39217	Ном	224,100.00	224,100.00
393	Биет бус хөрөнгө	10,739,500.00	10,589,500.00
39301	Програм хангамж	2,600,000.00	2,600,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,412,500.00)	(2,562,500.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	10,552,000.00	10,552,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>860,218,382.63</u>	<u>1,830,745,861.73</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>2,887,522.87</u>	<u>1,602,900.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,887,522.87	1,602,900.00
413	Өглөг	2,887,522.87	1,602,900.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,622,242.87	144,900.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	354,000.00	1,458,000.00
4136	Бусад өглөг	911,280.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	911,280.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>857,330,859.76</u>	<u>1,829,142,961.73</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	870,124,967.80	2,245,259,800.22
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	203,450,000.00	1,084,562,931.22
120	Нийтлэг татварын бус орлого	203,450,000.00	1,084,562,931.22
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,750,000.00	4,750,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,750,000.00	4,750,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	199,700,000.00	1,079,812,931.22
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	666,674,967.80	1,160,696,869.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	663,502,400.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	663,502,400.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,172,567.80	90,146,669.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,172,567.80	90,146,669.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	1,070,550,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	1,070,550,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	747,031,067.64	1,265,730,198.25
21	УРСГАЛ ЗАРДАЛ	747,031,067.64	1,265,730,198.25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	639,899,795.68	1,156,235,409.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	348,303,763.26	523,347,875.90
210101	Үндсэн цалин	236,445,720.89	338,593,196.23
210102	Нэмэгдэл	95,913,698.42	182,871,929.67
210104	Урамшуулал	15,944,343.95	1,882,750.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,561,426.69	68,334,300.00
210201	Тэтгэврийн даатгал	30,072,710.89	46,467,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,447,573.19	5,466,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,783,956.92	3,152,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	676,289.47	2,314,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,580,896.22	10,933,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,270,793.54	63,279,333.55
210301	Гэрэл, цахилгаан	10,727,273.54	18,316,347.35
210302	Түлш, халаалт	34,543,520.00	44,962,986.20
2104	Хангамж, бараа материалын зардал	29,340,036.18	33,657,278.01
210401	Бичиг хэрэг	3,049,600.00	4,156,200.00
210402	Тээвэр, шатахуун	21,609,776.18	17,868,288.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,380,660.00	3,439,090.01
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,300,000.00	8,193,700.00
2105	Нормативт зардал	48,000.00	-
210502	Хоол, хүнс	48,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,928,900.00	46,587,170.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	341,500.00	198,500.00
210602	Тавилга	-	2,000,000.00
210604	Урсгал засвар	3,587,400.00	44,388,670.00
2107	Томилолт, зочны зардал	11,707,100.00	15,932,600.00
210702	Дотоод албан томилолт	11,707,100.00	15,932,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил,		

	үйлчилгээний төлбөр, хураамж	97,356.00	2,211,684.40
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	900,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	49,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	210,280.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	203,400.00
210807	Газрын төлбөр	97,356.00	848,004.40
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	157,642,420.01	402,885,167.28
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	70,273,338.00	252,752,937.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,676,840.00	9,230,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	85,692,242.01	140,902,230.28
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	107,131,271.96	109,494,789.11
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00	39,222,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	39,222,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	106,631,271.96	70,272,789.11
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	106,115,023.24	69,284,789.11
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	516,248.72	988,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	123,093,900.16	979,529,601.97
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		7,717,500.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		7,717,500.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		(7,717,500.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	123,093,900.16	971,812,101.97

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	670,424,967.80	1,165,446,869.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,750,000.00	4,750,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,750,000.00	4,750,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,750,000.00	4,750,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,750,000.00	4,750,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	666,674,967.80	1,160,696,869.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	663,502,400.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	663,502,400.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,172,567.80	90,146,669.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,172,567.80	90,146,669.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	1,070,550,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	1,070,550,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	664,750,967.80	1,126,224,258.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	664,750,967.80	1,126,224,258.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	557,619,695.84	1,016,729,468.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	342,828,429.22	524,423,119.28
210101	Үндсэн цалин	228,730,159.42	339,668,439.61
210102	Нэмэгдэл	100,997,061.85	182,871,929.67
210104	Урамшуулал	13,101,207.95	1,882,750.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,744,199.00	68,334,300.00
210201	Тэтгэврийн даатгал	32,587,400.00	46,467,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,833,799.00	5,466,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,091,000.00	3,152,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	708,400.00	2,314,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,523,600.00	10,933,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	49,034,256.54	62,758,600.20
210301	Гэрэл, цахилгаан	10,727,273.54	18,316,347.35
210302	Түлш, халаалт	38,306,983.00	44,442,252.85
2104	Хангамж, бараа материалын зардал	25,427,477.08	33,588,778.01
210401	Бичиг хэрэг	2,635,400.00	3,982,100.00
210402	Тээвэр, шатахуун	18,060,917.08	17,868,288.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,380,660.00	3,439,090.01
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,350,500.00	8,299,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,765,400.00	47,430,170.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	632,000.00	853,500.00
210602	Тавилга	-	2,188,000.00

210604	Урсгал засвар	3,133,400.00	44,388,670.00
2107	Томилолт, зочны зардал	11,353,100.00	14,828,600.00
210702	Дотоод албан томилолт	11,353,100.00	14,828,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	97,356.00	2,211,684.40
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	900,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	49,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	210,280.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	203,400.00
210807	Газрын төлбөр	97,356.00	848,004.40
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	77,369,478.00	263,154,217.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	74,973,638.00	253,924,217.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,395,840.00	9,230,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	107,131,271.96	109,494,789.11
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00	39,222,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	39,222,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	106,631,271.96	70,272,789.11
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	106,115,023.24	69,284,789.11
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	516,248.72	988,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	5,674,000.00	39,222,611.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	5,674,000.00	39,222,611.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,674,000.00	39,222,611.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,674,000.00	39,222,611.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,674,000.00	39,222,611.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(5,674,000.00)	(39,222,611.00)

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	812019150.39	293342914.64	-311544953.43	793,817,111.60
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	812019150.39	293342914.64	-311544953.43	793,817,111.60
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	123093900.16	123,093,900.16
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	812019150.39	293342914.64	-188451053.27	916,911,011.76
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	812019150.39	293342914.64	-188451053.27	916,911,011.76
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	812019150.39	293342914.64	-188451053.27	916,911,011.76
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	971812101.97	971,812,101.97
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	812,019,150.39	293,342,914.64	783,361,048.70	1,888,723,113.73

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2.00	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	884,866,150.00	667,252,400.00	1,070,550,200.00	1,006,015,410.89
21.00	УРСГАЛ ЗАРДАЛ	884,866,150.00	667,252,400.00	1,070,550,200.00	1,006,015,410.89
210.00	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	884,866,150.00	561,137,376.76	1,028,728,200.00	966,793,410.89
2,101.00	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	454,329,600.00	342,828,429.22	535,043,600.00	524,423,119.28
210,101.00	Үндсэн цалин	363,453,100.00	228,730,159.42	380,228,000.00	339,668,439.61
210,102.00	Нэмэгдэл	90,876,500.00	100,997,061.85	154,815,600.00	182,871,929.67
210,104.00	Урамшуулал	-	13,101,207.95	-	1,882,750.00
2,102.00	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимт	57,416,400.00	47,744,199.00	66,880,500.00	68,334,300.00
210,201.00	Тэтгэврийн даатгал	39,220,800.00	32,587,400.00	45,478,700.00	46,467,300.00
210,202.00	Тэтгэмжийн даатгал	4,548,900.00	3,833,799.00	5,350,400.00	5,466,700.00
210,203.00	ҮОМШӨ-ний даатгал	3,639,100.00	3,091,000.00	3,059,100.00	3,152,100.00
210,204.00	Ажилгүйдлийн даатгал	909,800.00	708,400.00	2,291,400.00	2,314,700.00
210,205.00	Эрүүл мэндийн даатгал	9,097,800.00	7,523,600.00	10,700,900.00	10,933,500.00
2,103.00	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	59,564,700.00	49,034,256.54	63,220,200.00	62,758,600.20
210,301.00	Гэрэл, цахилгаан	9,416,200.00	10,727,273.54	20,616,200.00	18,316,347.35
210,302.00	Түлш, халаалт	50,148,500.00	38,306,983.00	42,604,000.00	44,442,252.85
2,104.00	Хангамж, бараа материалын зардал	33,769,800.00	23,986,896.00	45,643,800.00	39,398,841.01
210,401.00	Бичиг хэрэг	5,540,600.00	2,635,400.00	3,554,500.00	3,982,100.00
210,402.00	Тээвэр, шатахуун	22,179,500.00	16,565,336.00	20,658,400.00	16,088,351.00
210,403.00	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,250,700.00	3,380,660.00	4,230,900.00	3,439,090.01
210,404.00	Ном, хэвлэл	299,000.00	55,000.00	200,000.00	-
210,406.00	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,500,000.00	1,350,500.00	17,000,000.00	15,889,300.00
2,106.00	Эд хогшил, урсгал засварын зардал	19,250.00	9,384,400.00	80,322,100.00	59,083,781.00
210,601.00	Багаж, техник, хэрэгсэл	8,400.00	6,251,000.00	4,972,100.00	6,162,111.00
210,602.00	Тавилга	-	-	7,000,000.00	8,533,000.00
210,603.00	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	-	-	-
210,604.00	Урсгал засвар	10,850.00	3,133,400.00	68,350,000.00	44,388,670.00
2,107.00	Томилголт, зочны зардал	12,860,000.00	11,353,100.00	14,960,000.00	14,828,600.00
210,701.00	Гадаад албан томилолт	-	-	-	-
210,702.00	Дотоод албан томилолт	12,860,000.00	11,353,100.00	14,960,000.00	14,828,600.00
2,108.00	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,288,400.00	97,356.00	4,388,000.00	1,361,184.40
210,801.00	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,400,000.00	-	1,200,000.00	50,000.00
210,802.00	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	560,000.00	-	560,000.00	-
210,803.00	Даатгалын үйлчилгээ	469,100.00	-	469,100.00	49,500.00
210,804.00	Тээврийн хэрэгслийн татвар	427,700.00	-	227,700.00	210,280.00
210,805.00	Тээврийн хэрэгслийн оношлогоо	73,800.00	-	73,800.00	-
210,806.00	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	203,400.00	-	203,400.00	203,400.00
210,807.00	Газрын төлбөр	138,700.00	97,356.00	1,638,300.00	848,004.40
210,808.00	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний ху	15,700.00	-	15,700.00	-
2,109.00	Бараа үйлчилгээний бусад зардал	262,618,000.00	76,708,740.00	218,270,000.00	196,604,985.00
210,901.00	Бараа үйлчилгээний бусад зардал	259,214,600.00	74,312,900.00	186,966,600.00	187,374,985.00
210,902.00	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,403,400.00	2,395,840.00	31,303,400.00	9,230,000.00
213.00	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	106,115,023.24	41,822,000.00	39,222,000.00
2,131.00	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	106,115,023.24	-	-
213,101.00	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	106,115,023.24	-	-
2,132.00	Бусад урсгал шилжүүлэг	-	-	41,822,000.00	39,222,000.00
213,208.00	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	-	39,822,000.00	39,222,000.00
213,209.00	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	-	2,000,000.00	-
6.00	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	21.00
61.00	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	1.00
610,001.00	Төсвийн байгууллага	-	-	-	1.00
620,001.00	Удирдах ажилтан	-	-	-	3.00
620,002.00	Гүйцэтгэх ажилтан	-	-	-	15.00
620,003.00	Үйлчлэх ажилтан	-	-	-	2.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	89,158,669.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	89,158,669.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	89,158,669.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,779,937.00
210402	Тээвэр, шатахуун	1,779,937.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	850,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	850,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	86,528,232.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	86,528,232.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	89,158,669.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	89,158,669.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	89,158,669.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Завхан аймгийн Дөрвөлжин сумын ЗДТГ нь харьяалагдах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх бодлогын удирдамжаар хангах, Засаг даргаас бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь зохион байгуулалт, эрх зүй, аж ахуйн талаар болон Тамгын газрын тасаг албадын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, нутгийн захиргааны байгууллагыг чиглэн удирдахад нь Засаг даргад туслах, Хурал, Засаг дарга, доод шатны удирдлагыг мэдээллээр хангах үүргийг хэрэгжүүлдэг байгууллага юм.

“Төр засгийн бодлого шийдвэрийн хэрэгжилтийг оновчтой зохион байгуулж мэргэшсэн төрийн албан хаагчаар төрийн албыг бүрдүүлэн иргэдэд төрийн үйлчилгээг ил тод шуурхай тэгш хүртээмжтэй хүргэх сум орон нутгаа хөгжүүлэх” гэсэн зорилгыг тавин ажиллаж байна.

2024 онд Дөрвөлжин сумын ЗДТГ-аас “Иргэдэд төрийн үйлчилгээг ил тод шуурхай тэгш хүртээмжтэй хүргэх” гэж дэвшүүлсэн зорилтын хүрээнд үйл ажиллагааныхаа чиглэлийг тодорхойлж, 4 зорилтын хүрээнд 63 арга хэмжээг төлөвлөснөөс, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 86.0 хувиар, дүгнүүлсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Дөрвөлжин сумын ЗДТГ нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төрийн албаны тухай, Төсвийн тухай, Хөдөлмөрийн тухай, Шилэн дансны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, зэрэг хуулиудыг голлон мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомжтой холбоотой Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдлөг болгожээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дөрвөлжин сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэль* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дөрвөлжин сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 960.9 сая төгрөгөөр буюу 110 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Бараа материал	26,364.2	27,398.7	1,034.5
Үндсэн хөрөнгө	837,254.7	1,798,010.5	959,721.3
Нийт хөрөнгө	869,878.7	1,830,745.9	960,867.2
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	857,330.8	1,829,143.0	971,812.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	860,218.4	1,830,745.9	970,527.5

Бараа материал дансны үлдэгдэл 1.0 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 22.9 сая төгрөгийн бараа материал худалдан авч, 21.9 сая төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны хувьд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 950.8 сая төгрөгийн, сумын түүхт 100 жилийн ойтой холбоотойгоор иргэд, аж ахуйн нэгжээс хандиваар ирсэн 108.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаснаар 959.7 сая төгрөгөөр өссөн байна.

Засгийн газрын дансны үлдэгдэл 1,829.1 сая төгрөг болж 971.8 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 1,080.5 сая төгрөг, нийт зарлагыг 1,080.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг батлахдаа өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн, 10.0 сая төгрөгөөр бууруулан 1,070.5 сая төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрийн 63 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,070.5 сая төгрөгийн төсөв баталсныг 1,007.3 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, дээд шатны төсөв захирагчаас 63.2 сая төгрөгийн санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 943.3 сая төгрөг, дээд шатны төсөв захирагчаас 62.7 сая төгрөг, нийт 1,006.0 сая төгрөгийг урсгал үйл ажиллагаандаа зарцуулж, 70.2 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80101- Үндсэн үйл ажиллагааны зардал	728,884.4	693,929.9	34,954.5	95.2
2	80106-Багийн үйл ажиллагаа	146,631.7	142,873.1	3,758.6	97.4
3	81102- Засаг даргын нөөц сан	129,855.3	128,522.4	1,332.9	86.25
4	81701 Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх	80,488.4	58,761.1	26,477.3	99.0
5	80205 Мэдээлэл сурталчилгааны зардал	1,200.0	50.0	1,150.0	4.1
6	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	41,822.0	39,222.0	2,600.0	93.5

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсөв захирагчаас 88.3 сая төгрөг, хагас жилийн мал тооллогын зардал 1.5 сая төгрөг, хүүхэд хамгааллын хамтарсан багийн зардал 0.3 сая төгрөг, нийт 90.1 сая төгрөгийг бүртгэсэн байна.

Үүнээс Тээвэр, шатахууны зардалд 1.8 сая төгрөг, Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжид 0.8 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 85.5 сая төгрөгийг зарцуулж, 1.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус байгууллагад тусгайлан хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр байхгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дөрвөлжин сумын ЗДТГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Пүүжмаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар, дарга тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Дөрвөлжин сумын ЗДТГ-ын 2043 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 10 дүгээр сарын 04-ний өдрийн 513 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,265.7 сая төгрөгийн 1.5 хувь буюу 19.0 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой төсвийг хэмнэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.

Илрүүлэлт: Татварын давсан орлогоос 10.0 сая төгрөгөөр телевизийн нэвтрүүлэг бэлтгэсэн нь

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4-т “Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх гэж заасныг зөрчсөн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБООУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны хэрэгжилтийг шалгахад тайлант хугацаанд оруулах ёстой мэдээллүүдийг бүрэн оруулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжтой холбоотой алдаа зөрчил илрээгүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дөрвөлжин сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайланд завсрын аудитыг хийгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	11,406.7	1	11,406.7	100
Албан шаардлага	2	4,499.0	2	4,499.0	100
Зөвлөмж	2	0	2	0	100
Хууль хяналтын байгууллагад	1	48,300.0			0
Хариуцлага тооцуулах албан шаардлага	1	0	1	0	100
Нийт дүн	9	64,205.7	6	15,905.7	90.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар эд хөрөнгийн ашиглалт хамгаалалтын асуудалд анхаарах шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 814.7 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 726.9 сая төгрөгийн алдааг залрууллаа

Үүнд: Аудитын явцад Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн болон хандив тусламжаар ирсэн орлогод тусгаагүй байсан 726.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгүүдийг данс бүртгэлд тусгууллаа.

Аудитаар нийт 87.8 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 61.9 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 25.9 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

5.1 Төлбөрийн акт *Илрүүлэлт:* Төрийн албан хаагчийн 5 жилийн тэтгэмжийг 0.5 сая төгрөгөөр зөрүүтэй тооцон олгосон, ажил хавсран ажилласан албан хаагчийн цалинг 0.5 сая төгрөгөөр, томилолтын мөнгийг 0.7 сая төгрөгөөр цалингийн нэмэгдлийг 2 албан хаагчид 0.4 сая төгрөгөөр зөрүүтэй тооцон олгосон, цалин амралтын мөнгийг 2 албан хаагчид 3.8 сая төгрөгөөр давхардуулсан, төрийн албан хаагчдыг аялалд явуулж төсвөөс 20.0 сая төгрөгийн зарлага гарган өмнөх оны алдааг давтсан нь:

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-т "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41.2.2-д "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоол Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 2.3-т "Мөнгөн урамшууллын хэмжээг тодорхойлохдоо Төрийн албаны тухай хуулийн 51.3-т заасныг баримтлан тухайн төрийн захиргааны алба хаагчийн сүүлийн 12 сарын үндсэн цалингийн дунджийг 6 дахин нэмэгдүүлж тооцно", Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны А/191 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам"-ын 3.1-т "Ажилтны ээлжийн амралтын цалинг ээлжийн амралт эдлэхээс өмнө олгоно" гэж заасантай нийцэхгүй байна.

5.2 Албан шаардлага *Илрүүлэлт:* Няравын дансаар 9.9 сая төгрөгийг зарцуулахдаа бэлэн мөнгөний тайлан гаргаагүй; сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах, ортофото дэвсгэр зургийн үнэ 37.0 сая төгрөгийг гүйцэтгэгч аж ахуйн нэгж рүү гэрээ хийж, бүрэн шилжүүлсэн боловч зураг, төлөвлөгөөг гэрээний хугацаанд хүлээн аваагүй; Төрийн албан хаагчийн урлаг спортын наадам зохион байгуулж 5,0 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан зэрэг нь:

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", 41.2.6-т "төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-т "Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын аж ахуйн нэгж, байгууллагын төлөөний газар нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана", 14.2-т "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ давхар бичилтийн аргаар хөтөлнө", Сангийн сайдын 2017 оны Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх зааврын 2 дугаар хэсэг Бэлэн мөнгөний гүйлгээ, түүний хадгалалт хамгаалалт, бүрэн бүтэн байдлыг хангах зорилгоор бэлэн мөнгөний орлого, зарлагын баримтыг хөтөлнө. Байгууллагын удирдлагын шийдвэрийн дагуу хариуцсан нягтлан бодогч бэлэн мөнгөний орлого, зарлагын баримтыг бичиж нэг, хоёрдугаар гарын үсэг зурагдсаны дараа мөнгөний нярав зохих гүйлгээг хийнэ. “Бэлэн мөнгөний орлогын баримт”-аар бэлэн мөнгийг тоолж хүлээн авч, зарлагын баримтыг үндэслэн бэлэн мөнгийг хүлээлгэж өгнө. Эдгээр баримтуудыг 2 хувь үйлдэж, мөнгө тушаагч эсвэл хүлээн авагч нарт 1 хувийг өгч, холбогдох баримт бичгийн хамт 1 хувийг нярав хадгалан “Бэлэн мөнгөний тайлан”-д бичилт хийх үндэслэл болгоно. Бэлэн мөнгөний орлого, зарлагын баримтуудыг дагалдах баримт бичгийн хамт Бэлэн мөнгөний тайлангийн 1 хувьтай хавсарган, холбогдох нягтлан бодогчид тушаана. Бэлэн мөнгөний нярав тайлангийн 1 хувийг өөртөө хадгална”.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн хөрөнгүүдийг данс бүртгэлд тусгаагүй	1	714,869.6	1	714,869.6			1	714,869.6				
Хандив тусламжаар ирсэн үндсэн хөрөнгүүдийг данс бүртгэлд тусгаагүй	1	12,000.0		12,000.0			1	12,000.0				
Дүн	2	726,869.6	2	726,869.6			2	726,869.6				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Томиолтын мөнгийг зөрүүтэй тооцон олгосон болон сум дотроо томилолт тооцон олгосон	1	743.4	1	743.4							1	48,300.0
Цалингийн нэмэгдлийг 2 албан хаагчид зөрүүтэй тооцон олгосон /2 САД/	1	363.5	1	363.5								
Төрийн албан хаагчийн 5 жилийн тэтгэмжийг зөрүүтэй тооцон олгосон /илүү/	1	300.5	1	300.5								
Төрийн албан хаагчийн 5 жилийн тэтгэмжийг зөрүүтэй тооцон олгосон /дутуу/	1	197.8	1	197.8								
Ажил хавсарсан албан хаагчийн цалинг зөрүүтэй тооцон олгосон	1	524.1	1	524.1								
Цалин амралтын мөнгө давхардуулан олгосон/ ня-бо, бичиг хэрэг/	1	3,753.4	1	3,753.4								
Төрийн албан хаагч нарыг аялалд явуулахад төсвөөс зарлага гарган өмнөх оны алдааг давтсан	1	20,000.0	1	20,000.0								
Нярвын дансаар бэлэн мөнгө дамжуулан зарцуулахдаа бэлэн мөнгөний тайлан гаргаагүй	1	9,931.7			1	9,931.7						
Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах, ортофото дэвсгэр зургийн үнийг бүрэн шилжүүлсэн боловч зураг, төлөвлөгөөг гэрээний хугацаанд хүлээн аваагүй	1	37,000.0			1	37,000.0						
Төрийн хэмнэлтийн хууль зөрчин телевизийн нэвтгүүлэг бэлтгэсэн	1	10,000.0			1	10,000.0						
Төрийн албан хаагчийн урлаг спортын наадам зохион байгуулж зардлыг зориулалт бусаар зарцуулсан	1	5,000.0			1	5,000.0						
Сөрөг санал дүгнэлт авсан	1	0							1	1		
Дүн	14	87,814.4	7	25,882.7	4	61,931.7			1	1		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
-	-	-	-	-	-	-	-	-

БОЛОВСРУУЛСАН : АУДИТОР

Д.ПҮҮЖМАА 2025.02.24

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.БОЛДБААТАР 2025.02.25

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.БАТ-УНДРАА 2025.02.25

